

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
 2023 оны 07 сарын 24 өдрийн
 188 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
 7 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 121,821.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 108,537.1 мянган төгрөгийг зарцуулж 13,283.9 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	6-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
3	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	7 сард	Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт дуусч дүнг нэгтгэж байна.
4	Боржигин өв музейн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	7 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Боржигин өв музейн 2022-2023.05 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллагад "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэв. Аудитаар илэрсэн 7 асуудлын 5 асуудал буюу 71% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 10 зөвлөмж өгсөн.
5	Сүмбэр сумын ЗДТГ-2022 он, 2023 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	7 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Б Сүмбэр сумын ЗДТГ 2022-2023.05 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллагад "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэв. Аудитаар илэрсэн 7

				асуудлын 5 асуудал буюу 71% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 3 зөвлөмж өгсөн.
	Зургаадугаар цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	7 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022-2023.05 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллагад "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгсөн. Шалгалтаар 14 зөрчил илэрч илэрсэн зөрчлийн хүрээнд 17 заалттай 1 хугацаатай зөвлөмжийг Зургаадугаар цэцэрлэгт, аймгийн Боловсролын газарт цаашид авах арга хэмжээний 4 саналыг хүргүүлэв.
	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	7 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газарт 2022-2023.06 сар хүртэлх санхүүгийн болон үйл ажиллагааны баримтад санхүүгийн болон дотоод аудит хийлээ. танай байгууллагад "Эрсдэлгүй" буюу "Хангалттай" гэсэн дүгнэлтийг өгч байна.
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	7 сард	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Эхний 6 сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 94.8 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
8	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	7 сард	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 8 мэдээ байршуулсан. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлсэн.
9	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	7 сард	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 1 удаагийн хурлаас өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад 6 албан хаагч хамрагдсан. "Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, хяналт, шалгалтаар илэрч буй зөрчлийг багасгах, нэгдсэн мэдээлэл"-тэй болох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сургалтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит сэдвээр дотоод аудитор Л.Эрдэнэчимэг, Г.Насанжаргал нар

			төрийн болон ОНӨААТҮГазруудын дарга, ахлах нягтлан бодогч нарт арга зүйн сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хийлээ. Тус сургалтад 62 байгууллагын 100 албан хаагч хамрагдсан. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын Ойн ангийн зурвас газарт хувиарлагдсан 2014 оны талбайд мод арчилгаа, усалгааг VII/09, VII/24-ны хуваарьт өдрүүд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Мод бүрийн тогоог дахин засаж, тогоолж, усалгааны үйл ажиллагааны бэлтгэл хангасан. 2. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийг хогийг цэгт хаясан. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем дэх мэдээллийн бүрдүүлэлт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хийсэн шалгалтад 7 албан хаагчийн хувийн хэрэг болон цахим систем дэх мэдээллийн бүрдүүлэлтийг шалгуулахад зөрчилгүй байв.
--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг